



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 3 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 110

Улаанбаатар
хот

“Богдхан” төмөр зам болон “Улаанбаатар”
холимог тээврийн ложистик төвийг барьж
байгуулах талаар авч хэрэгжүүлэх зарим
арга хэмжээний тухай

Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Төмөр замын тээврийн тухай хуулийн 9.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Богдхан” төмөр зам болон “Улаанбаатар” холимог тээврийн ложистик төвийг барьж байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажлыг Азийн хөгжлийн банкнаас үзүүлэх техникийн туслалцааны хүрээнд зохион байгуулахыг Зам, тээврийн сайд Н.Төмөрхүүд зөвшөөрсүгэй.

2. “Богдхан” төмөр зам болон “Улаанбаатар” холимог тээврийн ложистик төвийг барьж байгуулахад шаардагдах хөрөнгийн асуудлыг Азийн хөгжлийн банктэй эцэслэн тохиролцож, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Зам, тээврийн сайд Н.Төмөрхүү, Сангийн сайд Ж.Эрдэнэбат нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Зам, тээврийн сайд

Н.ТӨМӨРХҮҮ